

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн .....	7
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	11
3.1 Зардлын данстай холбоотой асуудал.....	11
3.2 Зардлын данстай холбоотой асуудал.....	11
3.3 Зардлын данстай холбоотой асуудал.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН  
КОМИССЫН ДАРГА Я.САНЖМЯТАВ  
ТАНАА

2020.04.24 № 1326  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга Я.Санжмятав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийг зөв, бүрэн хөтлөх, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж ажиллах талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 05-аас 2020 оны 4 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Д.Болор-Эрдэнэ гүйцэтгэв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 301 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, нам, төрийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар хилсээр шийтгүүлсэн;
- Нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгуулах;
- Хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах;
- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршигт үр дагаврыг арилгах ажлыг зохион байгуулах гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганаар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 6.3-т цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гаргаж болох, 13.2.1, 13.2.2-т хэлмэгдэгчдэд шийтгэлийн төрлөөс шалтгаалан нөхөх олговрын хэмжээг 40.0 сая, 80.0 сая төгрөгөөр олгож байхаар хуульчилсан;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” батлагдсан;
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” батлагдсан;
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” батлагдсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталжээ.

## 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын шинэчлэлт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын бэлтгэсэн санхүүгийн тайлан болон жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дансыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 5,552.9 сая төгрөгийн 2 хувь буюу 111.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

### 2.8.1 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 12.3 сая, эцсийн үлдэгдэл 11.1 сая төгрөг болж, 1.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	2.3	1.4	(0.9)
Бусад хангамжийн материал	10.0	9.7	(0.3)
<b>Дүн</b>	<b>12.3</b>	<b>11.1</b>	<b>(1.2)</b>

*Эх сурвалж: ЦАУЗБУК-ын 2019 оны санхүүгийн тайлан*

Тайлант онд бараа материал худалдан авсан 7.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 9.0 сая төгрөгийн бараа материал зарцуулж, нийт үлдэгдлийн 87.0 хувийг албан ажлын хэрэгцээнд шаардагдах хангамж, бараа материал эзэлж байна.

## 2.8.2 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 51.3 сая, эцсийн үлдэгдэл 53.0 сая төгрөг болж, 1.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Машин, тоног төхөөрөмж	24.4	21.8	(2.6)
Тавилга, аж ахуйн эд хогшил	12.9	12.2	(0.7)
Номын фонд	8.5	8.5	-
Биет бус хөрөнгө	5.5	10.5	5.0
<b>Дүн</b>	<b>51.3</b>	<b>53.0</b>	<b>1.7</b>

*Эх сурвалж: ЦАУЗБУК-ын 2019 оны санхүүгийн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 17.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, тайлант хугацааны элэгдэл 16.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

## 2.8.3 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.02 сая төгрөгийг барагдуулж, эцсийн үлдэгдэлгүй болж буурсан байна.

*Хүснэгт №3 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	0.02	-	(0.02)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.02	-	(0.02)
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>0.02</b>		<b>(0.02)</b>

*Эх сурвалж: ЦАУЗБУК-ын 2019 оны санхүүгийн тайлан*

## 2.8.4 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 63.6 сая, эцсийн үлдэгдэл 64.1 сая төгрөг болж, 0.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/
Засгийн газрын хувь оролцоо	63.6	64.1	0.5
Өмч: -Төрийн өмч	50.3	50.3	-
Хуримтлагдсан үр дүн	12.5	13.0	0.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.8	0.8	-
<b>Дүн</b>	<b>63.6</b>	<b>64.1</b>	<b>0.5</b>

*Эх сурвалж: ЦАУЗБУК-ын 2019 оны санхүүгийн тайлан*

Засгийн газрын хувь оролцооны дансанд тайлант үеийн үр дүн 0.5 сая төгрөгөөр нөлөөлсөн байна.

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс санхүүжүүлэхээр 5,553.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 5,551.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,551.1 сая төгрөг буюу 99.9 хувьтай, 2.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй илүү болон дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

Тээвэр шатахууны зардал 2.0 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь Засгийн газрын автобаазын автомашиныг түрээсэлж, илүү цагийн буюу сул зогсолтын хөлс төлсөн нь нөлөөлжээ.

Урсгал засварын зардал 2.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь засварын ажлын төсвийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

## **2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг үнэлж, гаргалаа.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 84.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2.3 сая төгрөгийн алдааг залруулж, 37.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 44.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 2.3 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д “зохицох”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалд заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийх.

2. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны хуулийг мөрдөхгүй түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлахаар 37.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн “Худалдан авах ажиллагааны журмыг сонгох”, 12 дугаар зүйл “Тендерт оролцогчийн чадварыг үнэлэх”, 21 дүгээр зүйл “Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх”, 22 дугаар зүйл “Тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох”, 27 дугаар зүйл “Тендерийг хянан үзэх”, 28 дугаар зүйл “Тендерийг үнэлэх”, 29 дүгээр зүйл “Гэрээ байгуулах эрх олгох” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 44.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

## **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Улсын Их Хурлын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганаар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 6.3-т цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гаргаж болохоор заасан тул дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 162 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 5.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, мөн 0.8 сая төгрөгийн алдаа зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Залруулагдаагүй 82.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 111.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага, шинж чанарын хувьд материаллаг илэрхийлэгдээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлтийг өгч байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим чиглэгдсэн.

Энэ нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд нь цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүй 15.3 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2014 оны 55, 2018 оны 134 дүгээр тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Эдийн засгийн ангилал зөрчиж, ажил гүйлгээ бүртгэх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үндэслэлтэй боловсруулж батлуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

#### **3.2 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Худалдаж авсан 24.9 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3-т "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

**3.2.2 Эрсдэл:**

Зардал буруу илэрхийлэх, аккруэл сууриар бүртгээгүй байх.

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтлөх, бараа материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэх.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

**3.3 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

**3.3.1 Илрүүлэлт:**

Засгийн газрын автобаазаас дуудлагаар автомашин түрээсэлж илүү цагийн сул зогсолтод 4.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ын 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**3.3.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Дуудлагын автомашин ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, зардлыг хэмнэлттэй зарцуулах.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Үйлчлүүлэгч байгууллага асуудлын бүртгэлтэй танилцан, зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,314.4</b>	<b>11,064.0</b>
31	МӨНГӨ ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,314.4	11,064.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>51,290.6</b>	<b>52,999.8</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,290.6	52,999.8
392	БИЕТ ХӨРӨНГӨ	45,738.5	42,481.0
393	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	5,552.1	10,518.7
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>63,605.0</b>	<b>64,063.8</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24.1	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24.1	-
413	Өглөг	24.1	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>63,580.9</b>	<b>64,063.8</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	63,580.9	64,063.8
512	Хуримтлагдсан үр дүн	12,509.7	12,992.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	831.8
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>63,605.0</b>	<b>64,063.8</b>

##### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>647,587.5</b>	<b>5,553,436.7</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>647,587.5</b>	<b>5,553,436.7</b>
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>656,938.3</b>	<b>5,552,953.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>656,938.3</b>	<b>5,552,953.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>452,887.7</b>	<b>458,342.9</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	147,595.7	178,149.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,546.8	22,125.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,450.1	29,603.5
2104	Хангамж, бараа материалын зардал	36,129.0	23,948.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,017.0	4,210.8
2107	Томилолт, зочны зардал	49,860.9	14,325.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	115,022.9	148,247.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,265.5	37,732.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>204,050.6</b>	<b>5,094,610.9</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,766.3	5,092,292.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,284.3	2,318.6
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>- 9,350.8</b>	<b>482.9</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>- 9,350.8</b>	<b>482.9</b>

**4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
C01	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	69,837.4	-	69,837.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,931.7	-	72,931.7
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-9,350.8	-	-9,350.8
C08	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	63,580.9	-	63,580.9
D01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	63,580.9	-	63,580.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,580.9	-	63,580.9
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	482.9	-	482.9
D09	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	64,063.8	-	64,063.8

**4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>647,587.5</b>	<b>5,553,436.7</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>647,587.5</b>	<b>5,553,436.7</b>
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>627,754.0</b>	<b>5,535,608.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>627,754.0</b>	<b>5,535,608.6</b>
210	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>421,006.7</b>	<b>440,997.7</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	143,314.1	171,913.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,419.0	20,984.8
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	31,450.1	29,603.5
2104	Хангамж, бараа материалын зардал	28,904.5	22,168.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,017.0	4,210.8
2107	Томилолт, зочны зардал	41,181.6	14,325.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,426.5	156,178.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,294.0	21,614.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>206,747.3</b>	<b>5,094,610.9</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,463.0	5,092,292.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,284.3	2,318.6
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>19,833.5</b>	<b>17,828.1</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>19,833.5</b>	<b>17,828.1</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,833.5</b>	<b>17,828.1</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	19,833.5	17,828.1
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-19,833.5</b>	<b>-17,828.1</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,553,436.7</b>	<b>5,551,118.1</b>	<b>2,318.6</b>	<b>100.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,553,436.7</b>	<b>5,551,118.1</b>	<b>2,318.6</b>	<b>100.0</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	460,967.2	458,825.8	2,141.4	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,307.0	171,913.5	393.5	99.8
210101	Үндсэн цалин	118,809.6	118,619.7	189.9	99.8
210102	Нэмэгдэл	37,895.0	38,141.4	-246.4	100.7
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	15,602.4	15,152.4	450.0	97.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,538.4	20,984.8	553.6	97.4
210201	Тэтгэврийн даатгал	14,646.1	14,092.5	553.6	96.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,723.1	1,723.1	0.0	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	1,378.5	1,378.5	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	344.6	631.8	-287.2	183.3
210205	Эрүүл мэндийн даатгал	3,446.1	3,158.9	287.2	91.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,690.3	29,603.5	86.8	99.7
210304	Байрны түрээс	29,690.3	29,603.5	86.8	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	22,177.5	22,168.0	9.5	100.0
210401	Бичиг хэрэг	4,412.6	3,235.8	1,176.8	73.3
210402	Тээвэр (шатахуун)	9,217.1	10,886.6	-1,669.5	118.1
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,592.5	4,051.5	-459.0	112.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	4,955.3	3,994.1	961.2	80.6
2106	Эд хогшил худалдан авах	13,665.1	13,663.4	1.7	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,915.1	7,469.3	-554.2	108.0
210602	Тавилга	-	1,983.3	-1,983.3	-
210604	Урсгал засвар	6,750.0	4,210.8	2,539.2	62.4
2107	Томилолт, зочны зардал	14,353.9	14,325.0	28.9	99.8
210702	Дотоод албан томилолт	14,353.9	14,325.0	28.9	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	165,581.8	164,553.5	1,028.3	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,021.9	148,996.6	1,025.3	99.3
210806	Мэдээллийн технологийн зардал	15,559.9	15,557.0	2.9	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	21,653.2	21,614.0	39.2	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,853.2	3,814.0	39.2	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,800.0	17,800.0	0.0	100.0
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,092,469.5</b>	<b>5,092,292.3</b>	<b>177.2</b>	<b>100.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,092,469.5	5,092,292.3	177.2	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	5,088,495.7	5,088,318.5	177.2	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,973.8	3,973.8	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,553,436.7</b>	<b>5,551,118.1</b>	<b>2,318.6</b>	<b>100.0</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,553,436.7</b>	<b>5,551,118.1</b>	<b>2,318.6</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,553,436.7	5,551,118.1	2,318.6	100.0

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	-	-
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>11</b>	<b>11</b>	-	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>11</b>	<b>11</b>	-	<b>100.0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	7	7	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	4	4	-	100.0



### 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2019 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2020/4/СТА-ТЕЗ</b>	
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>		<b>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс</b>			<b>сая төгрөгөөр</b>
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүй 15.3 сая төгрөгийг зардал хооронд гүйлгэн зарцуулсан.	15.3	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Ууганбаатар Х.Хажидмаа Т.Алтанцэцэг
2	Худалдаж авсан 24.9 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд тусгасан.	24.9	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Ууганбаатар Х.Хажидмаа Т.Алтанцэцэг
3	Засгийн газрын автобаазаас дуудлагаар автомашин түрээсэлж илүү цагийн сул зогсолтод 4.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.	4.4	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Ууганбаатар Х.Хажидмаа Т.Алтанцэцэг
4	Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны хуулийг мөрдөж ажиллалгүй түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлахаар 37.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.	37.5	Албан шаардлага	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Д.Ууганбаатар Х.Хажидмаа Т.Алтанцэцэг
<b>Нийт зөрчлийн дүн</b>		<b>82.1</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 21

№ 01/204

Улаанбаатар хот

САГ-2020/4/СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны хуулийг мөрдөж ажиллалгүй түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлахаар 37,510.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан нь

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн "Худалдан авах ажиллагааны журмыг сонгох", 12 дугаар зүйл "Тендерт оролцогчийн чадварыг үнэлэх", 21 дүгээр зүйл "Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх", 22 дугаар зүйл "Тендерийн баримт бичиг, тэдгээртэй холбоотой мэдээллийг олгох", 27 дугаар зүйл "Тендерийг хянан үзэх", 28 дугаар зүйл "Тендерийг үнэлэх", 29 дүгээр зүйл "Гэрээ байгуулах эрх олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын Нарийн бичгийн дарга Д.Ууганбаатар, Нягтлан бодогч Х.Хажидмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР  
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:  
КОМИССЫН НАРИЙН БИЧИЙН ДАРГА  
Д.УУГАНБААТАР  
НЯГТЛАН БОДОГЧ  
Х.ХАЖИДМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



